

Тодруулга хариу

Эрдэнэс-Таван толгой ХК одоо ашиглаж байгаа тоон станцууд нь Kenwood фирмийн NX-3220 маркийн гар станц, NX-3720 маркийн машины станцууд болон NXR-5700 маркийн дахин дамжуулах станцууд NXDN Type-C, Multi-Site Trunked горимоор нэг ба хоёрдугаар дэд хэсэг болон ашиглагдаж байгаа болно. Өөрөөр хэлбэл дэд хэсэг тус бүр нэг нэг удирдлага хяналтын суваг буюу Control Channel (CC) болон нэг ба хоёр ярианы суваг буюу Talk Channel (TC) үүсгэн ашиглагдаж байгаа бөгөөд тус Тендерийн зорилго нь одоо ашиглагдаж байгаа системийн багтаамж цар хүрээг нэмэгдүүлэх, уурхайн хөрсний тэлэлтээс үүсэн гарч байгаа хэрэгцээнд тулгуурлан нэмэлтээр гурав ба дөрөвдүгээр дэд хэсгүүдийг бий болгож өөр хооронд нь холбон нэгдсэн нэг сүлжээ үүсгэх, уг сүлжээг уурхайн сервер болон УБ дахь серверүүдээс хянах, удирдан зохицуулах мөн өөр хоорондоо дурын хэрэглэгчтэй шууд холбогддог байх боломжийг бүрдүүлэхэд оршиж байгаа бөгөөд энэ тухай тус тендерийн материалын **“Радио станц, Дэд систем, Түүний техникийн тодорхойлолт шаардлага”** хэсэгт дэлгэрэнгүй тусгасан байгаа.

А- Тендерийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай байгаа бараа болон холбогдох үйлчилгээний техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлоход оршдог бөгөөд тухайн тендерийн үр өгөөжийг хангах үүднээс техникийн шаардлагад нийцэхгүй буюу тохирч дэмжиж ажиллах боломжгүй эсвэл тохирох эсэх нь батлагдаагүй буюу туршигдаагүй мөн огт тохирохгүй байгаа бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээнээс захиалагч бүрэн татгалзана.

Б- Тухайн Тендерт оролцогч нь тендерийн техникийн тодорхойлолтод зааснаас өөр загвар, модель шинж чанар бүхий бараа бүтээгдэхүүн санал болгох бол одоо ашиглаж байгаа систем болон төхөөрөмжүүдтэй бүрэн зохицож, тухайн системийг дэмжиж, ажиллах боломжтой эсэхийг баримтаар нотлох.

1)

- а) “Тоон дахин дамжуулахын лиценз 2 багц” гэж шинээр үүсгэх хоёр дэд хэсгийг NXDN Type-C, Multi-Site Trunked горимд ажиллуулахад тэдгээрийг тухайн системд таниулан идэвхжүүлэхэд ашиглагдах бөгөөд манай одоо ашиглаж байгаа нь “KSL-2NW Repeater Multi-Site Repeater License” болно. Тендерт оролцогч нь KSL-2NW буюу түүнийг орлуулж болохуйц, одоо байгаа системийг шууд өргөтгөн ажиллах боломжтой, бүрэн зохицож ажиллах чадвартай адил үүрэг зориулалт бүхий түүнтэй дүйцэх лицензийг санал болгоно. (А-г харах)
- б) Дахин дамжуулагчийг холбох дэд систем нь өндөр хурдны радио линк ба нэвтрүүлэх хүлээн авах антенн, үл таслах тэжээл хангамж, 16-с багагүй портын свич, тэдгээрийн холбох кабел зэрэг багтана.
- в) Эрдэнэс-Таван толгой ХК одоо ашиглаж байгаа тоон станцуудад тохирч ажиллах боломжтой программ хангамж нь KAS-10 болон KAS-20 байгаа бөгөөд Тендерт оролцогч нь KAS-20-г буюу түүнийг бүрэн орлуулж болохуйц, одоо ашиглагдаж байгаа станцуудыг болон системийг дэмжиж ажиллаж чадахуйц буюу бүрэн зохицож ажиллах, адил үүрэг зориулалт бүхий техникийн тодорхойлолтод тусгасан шаардлагын дагуу, дүйцэх программ хангамжийг санал болгоно (Б- харах).

- 2) ЭТТ-н одоо ашиглагдаж байгаа станцууд нь Multi-Site Trunked горимд ажиллахдаа KWD-3501TR лиценз (license key for Digital Trunking) ашиглан системд бүртгэгдэн ажилладаг бөгөөд Тендерт оролцогч нь энэ шаардлагыг бүрэн хангаж чадахуйц бөгөөд орлуулж болохуйц бүтээгдэхүүнийг санал болгоно (Б-г харах). Лицензийн хугацаа хязгаартай буюу жил болгон сунгадаг байхыг хүлээн зөвшөөрөхгүй.
- 3) Дүйцэхүйц байж болно. (А-г харах)
- 4) Дүйцэхүйц байж болно. (А-г харах)
- 5) Дүйцэхүйц байж болно. (А-г харах)
- 6) Дүйцэхүйц байж болно. (А-г харах)